

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№18/479

ШУС, НУС

2017

СЭТГҮҮЛЧ Б.ХАЙСАНГИЙН УЛС ТӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРИМ АСУУДАЛ

Л.Норовсүрэн*

*МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн гэрээт профессор, Шинжлэх ухааны доктор (Sc.D)

Түлхүүр үг: улс төр, сэхээтэн, түүхийн баримт, иргэн, ноёрхол, эрх чөлөөний тэмцэл, Манжийн төр, Харбин, төлөөлөгч, харилцаа, эрх мэдэлтэн, Дорно дахины хэлтэс, Хиагт, тусгаар тогтнол

Энэхүү өгүүллийн зохиогч өмнө нь МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг “Сэтгүүл зүй” цувралын 2010 оны №11 (337) дугаарт Өвөр Монголын эрдэмт түшмэл, монгол туургатны ууган сэтгүүлчдийн нэг Хайсан гүнгийн тухай бэсрэг өгүүлэл нийтлүүлж байсан билээ. Тэр өгүүлэлд Хайсангийн амьдрал үйлс, түүний дотор сэтгүүлчийн ажил эрхэлж байсан цаг хугацааны ээдрээг тайлахыг оролдсон юм. Энэ удаа түүний улс төрийн үйл хэргийг тодруулахыг зорилгоо.

Хайсангийн амьдрал, үйл ажиллагааг улс төрийн зүтгэлтэн, эрдэм боловсролтой сэхээтэн, үндэсний ууган сэтгүүлчдийн нэг гэсэн гурван чиглэлээр авч үзэж болох боловч эдгээрийн дотроос улс төрийн үйл ажиллагаа нь бусдаасаа илүү жин

дарж байсныг түүхийн баримтуудаас харж болохоор юм.

Юуны өмнө тэрээр монгол үндэстний тусгаар тогтнолын төлөөх тэмцэлд бие сэтгэл, эрдэм мэдлэгээ харамгүй зориулсан нэгэн байжээ. XIX зууны дунд үеэс Чин улсын засгийн газар “Иргэнийг шилжүүлэн суулгаж, хязгаарыг өрнүүлэн бадруулах” нэрээр халхавч хийж Өвөр Монголын нутагт хятад иргэдийг олноор суулгаж, чуулган, хошуудад тэдний Хэрэг эрхлэх газруудыг байгуулан шууд ноёрхох бодлого явуулж эхэлсэн үеэс Хайсангийн улс төрийн тэмцэл эхэлсэн байдаг. Хэрэг эрхлэх газрын түшмэлүүд аливаа зөрчил маргаантай асуудлыг шийдвэрлэхдээ Өвөрмонголд ирж суурьшсан хятад иргэдийн талд илэрхий үйлчилж, уугуул монголчуудыг шахах бодлого баримталж байсан нь Хайсангийн дургүйцлийг төрүүлдэг байжээ. Үүний улмаас тэрээр орон нутгийн удирдагчидтай зөрчилдөж, улмаар уг бодлогыг явуулж байгаа Манжийн төрийн бодлогыг эсэргүүцэх үзэл нь лавширч байв. Тэрээр шударга тэмцлийнхээ улмаас ихэс дээдэст

хавчигдан гадуурхагдаж, улмаар 1902 онд Харчин баруун хошууны вангийн ордны цэргийн мэйрэнгийн тушаалаа орхин нутгаасаа дүрвэн гарч Харбин хотод очиж суурьшсан байна.

Хайсанг Харбин хотод Оросын консулын газарт ажилласан, Дорнод Хятадын төмөр замын оросын захиргаанаас эрхлэн гаргаж байсан “Монголын сонин бичиг” сонины найруулагч байсан гэх зэрэг мэдээллүүд ном бичигт тэмдэглэгдсэн байдаг ч тэдгээр мэдээллийн цаг хугацаа ихээхэн зөрүүтэй байдаг. Академич Б.Ширэндэв “XIX-XX зууны зааг дахь Монгол орон” гэдэг номдоо “Хайсан Харбин дахь Дорнод хятадын төмөр замын Оросын захиргаанаас гаргаж байсан “Монголын сонин бичиг” гэдэг монгол хэл дээр гарч байсан цорын ганц сонины эрхлэгч байсан”¹ гэсэн мэдээллээ “Монгол ардын хувьсгалын түүх”² гэдэг бүтээлдээ дахин нотолсон байдаг. Хэвлэлийн түүх судлаач, доктор Г.Дэлэг “Харбины монголын сонин эрхэлж байгсдын дотор Өвөр Монголын Харчин хошууны Алмас-Очир мэйрэн, Хайсан гүн нар байв. Тэд бол Манжийн колоничлолыг үзэн ядаж, тусгаар тогтносон нэгдмэл Монгол улс байгуулахыг эрмэлзэж байв”³ гэж бичсэн нь бий. Мөн Хайсанг Харбин дахь Оросын консулын газарт хэлмэрчээр ажиллаж байхад консул Симонов “Гадаад Монгол тусгаар тогтнолынхоо төлөө тэмцэж эхэллээ. Тэнд эрдэм мэдлэгтэй хүн их хэрэгтэй байна. Чи тийшээ оч гэсний дагуу 1907 онд Монгол руу явсан”⁴ гэж Хятадын судлаач Бай Юйкүний бичсэн зүйл ч байна. Бас Финландын монголч эрдэмтэн Рамстедтыг “1909 онд ИхХүрээнд ирэхэд Хайсан харбинд гарсан анхны монгол бичгийн сонины найруулагчаар хэдэн жил ажилласан тухайгаа дурсаж

байсан гэж ярьсан”⁵ тухай ном бичигт тэмдэглэсэн байна. Гэтэл бас Японы эрдэм шинжилгээний сэтгүүлд Т.Наками бичихдээ “Хайсан Харбинд байсныхаа дараа Бээжинд На вангийн ордонд алба хааж байсан”⁶ гэжээ. Эдгээр мэдээллүүдийг нарийн магадлах хэрэгтэй юм.

Хайсан Ар Монголд ирсэн цаг хугацаа ч бас маргаантай. Ар Монголд өрнөж эхэлсэн үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнд хүч мэдлэгээ зориулахыг өөрийнх нь ажиллаж байсан Оросын консул зөвлөсний дагуу Хайсан 1907 онд Өргөөнд ирсэн гэж Хятадын судлаач Бай Юйкүнь бичсэн байдаг. Финландын монголч эрдэмтэн Рамс-тедтыг 1909 онд Их Хүрээнд ирэхэд Ханддорж чин ван Өвөр Монголоос ирсэн өндөр нуруутай, цоохор нүүртэй Хайсан гэдэг хүнийг газарчнаар явуулсан тухай доктор Л.Жамсран бичсэн байна. Рамстедт эрдэм шинжилгээний зорилгоор Монголд гурван удаа (1898, 1909, 1912 онуудад) аялсан хүн юм. Тэдгээрийн алинд ч Хайсан гүн газарчилж явсан тухай баттай баримт алга.

1898 онд Хайсан гүн төрсөн нутаг Өвөр Монголдоо боломжийн ажил алба эрхэлж байсан тул Рамстедттэй уулзах боломжгүй байсан бол, Монголын үндэсний эрх чөлөөний тэмцэлд гарамгай гавьяа байгуулсны учир 1912 он гэхэд Богд хаант Монгол улсын Дотоод яамны орлогч сайдын алба хаших болсон байжээ. Иймээс цаг хугацааны хувьд Рамстедтэй хамт аялсан байж болох үе нь түүнийг угсаатны зүй, хэлшинжлэлийн судалгаагаар үргэлжлүүлэхээр Монголд хоёр дахь удаагаа ирсэн 1909 он байх бололцоотой юм. Гэтэл түүнийг хоёр дахь удаагаа Монголд ирэхэд өөртэй

нь танилцуулахаар чин ван Ханддоржийн явуулсан хүний тухай бичихдээ “Бадарчин гэж бодмоор цагаан бурханы сэвхтэй, өндөр нуруутай, царай муутай өвөрмонгол хүнийг илгээсэн байв. Энэ хүн бол Өвөр Монголд шүүгч түшмэл байсан Хайсан гүн гэдэг хүн ажээ” гээд тэр хүн яриагаа эхлэхийн өмнө хоёр талын үйлчлэгчээ хоногоор явуулчихъя гэж чихэнд нь шивнэсэн тухай өгүүлсэн байдаг.

Рамстедт «Үйлчлэгч Даржаа, Балжир хоёрыг гарч явсны дараа Хайсан гүн гэгээнтнээс (Богд Жавзандамба хутагт-Л.Н) заавар авах болон адис хүртэхээр итгэл дүүрэн аялж ирсэн бадарчин гэдгээ батлан хэлсэн юм. Миний адис хүртэх нь надад онцгой үнэ цэнтэй хэмээн тэр хэлэв. Тэрээр дарлагдсан монголчуудын оюун санааны бүхий л зовлонгийн тухай ярив. Наян найман хан, вангийн дөчийнх нь улс төрийн үзэл бодол тодорхой байгаа гэж тэр хэлэв. Тэрээр бүгдтэй нь уулзсан байна. Тэдний зарим нь ирэх аюулаас айж эмээж байхад, нөгөө зарим нь юу ч мэдэхгүй, гурав дахь хэсэг нь архинд донтсон байж үр бүтээлгүй болсон байна» хэмээн бичсэн боловч судалгааны аяллаар хамт явсан тухай дурьдсан зүйл байхгүй.

Тэгэхээр «Финляндын монголч эрдэмтэн Рамстедтыг 1909 онд Их Хүрээнд ирэхэд Ханддорж чин ван Өвөр Монголоос ирсэн өндөр нуруутай, цоохор нүүртэй Хайсан гэдэг хүнийг газарчнаар авч явахыг зөвлөхөд Рамстедт зөвшөөрч, тэд Их Хүрээнээс хамт хөдөлсөн. Тэгээд зам гудас элдвийг хөөрөлдөх зуур Хайсан Харбинд гарсан анхны монгол бичгийн сонин найруулагчаар хэдэн жил ажилласан тухайгаа дурсаж байсан хэмээн

Рамстедт ярьсан” гэж Л.Жамсрангийн бичсэний дотор магадлууштай зүйл байна. Рамстедт Монголд аялсан тухай дурсамж тэмдэглэлийн номдоо Хайсанг газарчнаар авч явсан тухай огт дурьдаагүй байна.

Тэрээр номдоо «Хайсан гүн онцгой хүн байв. Хэдэн жилийн турш тэрээр Харбинд монгол хэлээр анхны сонин хэвлүүлж байсан бөгөөд Монголын түүхийн тухай бүтээлийг монгол хэлээр бичсэн байна. Тэр бас Хятадын дээд албаны түшмэл болох шалгалт өгч байсан бөгөөд Хятадын нэг удирдагч бөгөөд дипломатч Ли Хунчаны монгол нарийн бичгийн дарга, сүүлд Оросын нууц цагдаагийн төлөөлөгчийн албанд зүтгэж байжээ. Тэрээр Хятадад ажил төрөл, эд хөрөнгөө алдсан болохоор эндээс мөнгө цуглуулахыг хүсч байлаа. Оросын төлөөлөгч байхдаа Сибирьт амьдардаг буриадуудын дунд аялах урилга хүлээн авсаны дээр оросууд амласан ёсоор аяллын төлбөрийг төлсөн байна. Түүнд явах нөхцөл бүрдээгүйн зэрэгцээ монголчуудад тусгаар тогтнолоо сэргээн мандуулах арга зам олдох ёстой гэсэн бодол нь саад болсон байна»⁷ гэжээ. Рамстедт Монголд 1898 онд магистр Сахари Палситэй, 1909 онд монгол газарчин Даржаатай, 1912 онд Арво Сатавалтатай хамт аялсан тухайгаа тодорхой бичсэний дотор Хайсангийн нэр дурьдагдаагүй байна.

Үүнээс үзвэл Хайсан гүн Ар Монголд ирэнгүүт Богд гэгээнтэй уулзаж, Чин улс дотооддоо хямран тэмцэлдэж байгаа завсар чөлөөг ашиглан тусгаар тогтнолын төлөө тэмцэл өрнүүлэх зориг санаагаа илтгэж, хувьсгалын үйл хэрэгт хоёргүй сэтгэлээр зүтгэж эхэлсэн нь тодорхой байна. Хайсан гүн Монголын тусгаар тогтнолын үйл хэрэгт хаант Оросоос тусламж гуйх, эс

бүтвэл Японд хандах бодолтой байжээ. Энэ зорилгоо хэрэгжүүлэхээр Чин ван Ханддорж, Да лам Цэрэнчимэд нарын хамт 1910 оны намар Орос орныг зорьжээ.

Тухайн үед Оросын Засгийн газрын аль нэг байгууллагатай харилцахын тулд эхлээд Монголд суугаа Ерөнхий консулаар дамжуулан Санкт Петербургээс зөвшөөрөл авах ёстой байв. Гэтэл тусгаар тогтнолын төлөө Оросоос тусламж гуйхаар явахыг Их Хүрээнд суугаа Манжийн амбан хэрхэвч зөвшөөрөхгүйг тэд мэдэж байлаа. Энэ шалтгаанаар Их Хүрээ-нээс нууцаар гарсан гурван төлөөлөгч Санкт Петербургт очоод нэгд урьдчилан тохирсон товгүй, хоёрт ямар ч бичиг баримт, биеийн байцаалтгүй, гуравт тэр учраа тодорхой илтгэх хэлний бэрхшээлтэйн улмаас хоёр улсын харилцаа ярих байтугай хардлага сэдлэгэд өртөж цагдаад журамлуулах дээр тулсан байна. Энэ байдлаас гарахын тулд Хайсан өөрийн хуучин танил Рамстедтэд захидал илгээжээ.

Энэ тухайд Рамстедт «1910 оны намар санаандгүй байтал би Санкт Петербургээс захидал хүлээн авлаа. Сайтар шалгаж үзвэл миний өөртөө хаяглаж гараар бичсэн дугтуй мөн байв. Захиаг монгол бичгээр бичиж, Хайсан гүн гарын үсгээ зуржээ. Тэрээр Санкт Петербургт Ханд ван, Хүрээний Да лам хоёртой хамт иржээ. Тэдний хэрэг явдал ээдрээтэй, зовлон бэрхшээл учирч байгаа тул намайг Санкт Петербургийн Невскийн гудамж дахь буудалд хүрэлцэн ирэхийг гуйсан байв. Би Лахти дахь охид хөвгүүдийн сургуулиасаа хэдэн өдрийн чөлөө авч Петербург рүү мордлоо. Тэнд би гурван монголыг амархан олсон. Хайсан гүн маш их баярлаж байсан

бөгөөд тэрээр Рамстедт л бидний хэрэг явдлыг эмх цэгцэд нь оруулж өгөх болно гэж байв»⁸ хэмээн бичиж үлдээсэн байна.

Төлөөлөгчид Санкт Петербургт Оросын цэргийн яамны удирдлагуудтай уулзаж тусгаар тогтнолын төлөөх тэмцэлд ашиглах 20 000 буу, бас пулемёт болон их буу зэрэг зэр зэвсэг гуйх зорилготой очжээ. Рамстедт гурван монгол хүн тусгаар тогтнолын төлөө тэмцэж байгаа олон монголчуудын хүсэл зорилгыг тээж, тэдний эрх олгосноор хүрч ирснийг учирлаж, «Эдгээр эрчүүдийн нэг нь Монголын эрхэмсэг ханхүү, ван гэдэг бол 60 000 хүнийг захирдаг албан тушаал юм. Нөгөөх нь Их Хүрээний 20 000 лам нарын тэргүүн болохоор ямар ч муу юм хийхгүй бөгөөд энэ гурвыг энгийн хүнтэй яав ч адилтгаж болохгүй» гэх мэтээр тайлбарлаж байж цагдаагийн мөрдлөгөөс чөлөөлсөн байна. Рамстедтийн ачаар Оросын Цэргийн яамны эрх мэдэлтнүүдтэй уулзаж монголчууд буу зэвсэг, сайн удирдагчаас гадна орос офицерүүдийн заавартай бол тусгаар тогтнолын тэмцэлдээ ялалт байгуулах бололцоотой гэдгээ учирласан байна.

Цэргийн яаманд болсон яриа хэлэлцээнд Оросын тал Рамстедтийг оролцуулахыг хүсээгүй учир Хайсан гүн хэрэг явдлаа мэдээлж, тэр нь оросуудын сонирхлыг татсан байдаг. Гэвч уг хэлэлцээний явцад Цэргийн яам монголтой харилцах харилцааг Финлянд, Оросын хоорондох харилцаатай адил байлгах нөхцөл тавьсан бөгөөд тэр нь Оросын Цэргийн яам монголд үнэхээр туслахыг хүсэхгүй байгаагийн илрэл төдийгүй, Оросын хүч чадал үлэмж их гэдгийг харуулах гэсэн хэрэг байсан гэж Рамстедт хожим дүгнэн бичсэн байдаг.

1911 оны 12 дугаар сард Нийслэл Хүрээнд болсон хан, вангууд хийгээд бусад төлөөлөгчдийн хуралдаанаар Монгол улсын тусгаар тогтнолыг албан ёсоор зарлажээ. Засгийн газар үндэсний эрх чөлөөний тэмцлээр олж авсан тусгаар тогтнолоо дэлхийн нөлөө бүхий улс орнуудаар хүлээн зөвшөөрүүлэхийг чухалчилж байв. Хайсан гүн бичиг эрдэм сайтай, дипломат ёсны зохих мэдлэгтэй хүн болохын хувьд «Тусгаар тогтнолын тунхаглал»-ын эхийг боловсруулах, мөнхүү зорилгоор Англи, Герман, Франц зэрэг орнуудад бичиг илгээх зэрэгт чухал үүрэгтэй оролцсон байна. Уг тунхаглалыг зөвшөөрүүлэхэд хамгийн их найдвар тавьж байсан Хаант Орос улсад хандсан хүсэлтийг монгол бичгээр бичиж, орос хэлээр орчуулаад Хүрээн дэх Консулын газраар дамжуулан Санкт Петербургт илгээсэн аж. Хайсан гүн Монголын тусгаар тогтнолын асуудлаар Бээжин дэх Английн дипломат төлөөлөгчийн газрын ажилтан Бинстидэд англи хэлээр, Халимагийн ван Балтад тод үсгээр захиа бичүүлэх, Оросын «Новая время» сонинд зориулж өгүүлэл бичүүлэх зэрэг ажлыг дотно танил Рамстедтэд хариуцуулан гүйцэтгүүлж байсан баримт ч байна.

Чин ван Ханддорж, Да лам Цэрэнчимэд, Хайсан гүн нар «Тусгаар тогтнолын тунхаглал»-ын хувь заяанд сэтгэлээ чилээж, хол ойрын хүнээс сайн мэдээ сонсохыг тэсч ядан хүлээж байлаа. Тэд Хаант Оросын Сангийн яамны Дорно дахины хэлтэст ажиллаж байсан монгол судлаач В.Котвичээр удирдуулсан Оросын Шинжлэх Ухааны Академийн эрдэм шинжилгээний экспедиц Нийслэл Хүрээнд ирэх сургийг сонсонгуут хил дээрх Хиагтад майхан сав

барьж, цэрэг жагсаан тосож угтаад, улмаар Нийслэл Хүрээнд ирэхэд нь Засгийн газрын түвшинд нүсэр хүлээн авалт зохион байгуулж хүндэтгэл үзүүлсэн байдаг. Энэ хүндэтгэлийг гагцхүү эх сурвалжид ойр байдаг В.Котвичээс Оросын засгийн газар Монголын тусгаар тогтнолын талаар ямар байр суурьтай байгааг лавлаж мэдэх зорилгоор үзүүлсэн байна.

Энэ зорилгоор Ханддорж, Цэрэнчимэд нар Котвичид гурван асуулт тавьсан байдаг. Рамстедтээр хэлмэрчлүүлэн тавьсан тэр асуултын эхнийх нь «Монголын тусгаар тогтнолын их хэргийн талаар оросууд ямар бодолтой байна, Тэд Монголыг тусгаар тогтносон орон гэж үзэж байна уу?» гэсэн асуулт байсан бол, хоёр дахь нь «Оросууд бидний тусгаар тогтнолыг дээд зэргээр хамгаалахын тулд бид юу хийх ёстой вэ?» гэсэн асуулт байв. «Орос орон өөр юуны ч төлөө биш, зөвхөн өөрийн болгосон улс орны төлөө л ажиллана. Тусгаар тогтнолын тунхаглалын баримт бичгийг огт анхаарахгүй байгаа шүү дээ» гэсэн Котвичийн үг дээрх хоёр асуултын нэг хариу болов. Гурав дахь асуулт нь Элчин консул Люба юм болгон дээр “эзэн хааны нэрийн өмнөөс” гэж далайлган Монголын хэрэгт оролцож байсантай холбоотой байв. Тодруулбал «Монгол улсын Засгийн газар Оросын консулын зааврыг дагах ёстой юу, эсвэл өөрөө бие дааж асуудлаа шийдэх ёстой юу?» гэсэн асуулт байлаа. В.Котвич «Консулын үгийг дагах ёстой» гэж шууд хариулжээ. Монголын сайдууд Оросын байр суурийг сонсож ихэд бухимдсан тухай Рамстедт тэмдэглэж үлдээсэн байдаг.

1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдагчдын дотор Хайсан гүн гадаад хэл, улс төрийн мэдлэгээрээ

давуу байсан тул бусад нь түүний үгийг анхаарч сонсдог байжээ. Тусгаар тогтнолын хэрэгт гавьяа байгуулсны учир «Харчин ван Гүнсэнноровын хошууны дэд зэрэг түшмэл Хайсанд үе улирах чин зүтгэлт цол, улсад туслагч гүн, отго, хүрэн жолоо, жич: Халхын дотор улаа шагнаж, Дотоод яамны дэс түшмэлийн оронд тохоон талбигтун!» гэсэн Богд хааны зарлигийн дагуу Засгийн газраас Хайсангийн хувийн амьдралыг төвхнүүлэх зорилгоор 1912 оны хавар улсын сангаас нэг зуун тэмээ ачаа хөсөг гарган өгч, Сэлэнгийн Буур зэрэг зургаан харуулын нутгийг эзэмшүүлэн, уул нутгаасаа гэр бүл, садан төрлийнхөө тавь гаруй хүнийг татан авчирч суурьших зөвшөөрөл олгожээ. Энэ цагаас Хайсан Монголын тусгаар тогтнолыг бэхжүүлэх тэмцэлд чин сэтгэлээр зүтгэж эхэлсэн байна. Түүнд үзүүлсэн хүндэтгэлийг Монголын зарим сайд ноёд эхнээсээ таагүй хүлээн авсан байдаг. Үүнийг ч тэрээр мэдэрч байсан баримт бий. Хайсанг хавчиж гадуурхах хэрэгт Оросын консулын гар хөл оролцсон байх ч магадлал байна. Түүнийг дэд сайд болмогц Элчин консул Люба дуудан уулзаж «Өвөр Монгол хүн Засгийн газраас гарч, зөвхөн халх монгол хүнийг оруулах ёстой»⁹ хэмээн шаардсан тухай Хайсан итгэлт нөхөр Рамстедтэд хэлсэн байдаг.

Хайсанг Хятадын хар цэргийн дарангуйллаас нутаг нэгтнүүдээ чөлөө-

лөхөөр тэмцэж явах хойгуур Шүүх яамны сайд чин ван Намсрай, Гадаад яамны дэд сайд Раашминжүүр нар зарга мэдүүлж, улмаар шүүх түүнийг нь гүйцэд нягтлалгүйгээр улс төрөөс урвасан гэх үндэслэлээр баривчилж, хатуу чангаар эрүүдэн шүүсэн байна. Хамтран зүтгэгч да лам Цэрэнчимэдийн уйгагүй хөөцөлдлөгийн ачаар Хайсан суллагдаж, урьдын эрх ямба, хэргэм зэргийг эдлэх болсон хэдий ч улс төрийн эр зориг нь ямар нэг хэмжээгээр мохсон байдаг. Тэрээр

Намсрайтай дахин заалдсан өргөдөлдөө «Өчүүхэн Хайсан миний бие оршихорон, идэх будаагүйн учир гадагш хэсээгүй. Чухам шарын шашин, монгол аймгийг үүрд бататгахын зүг хичээн зүтгэж арваад жил энд тэнд зовон зүдэрч явсныг дотоод, гадаадын эм хүүхэд хүртэл цөм мэдэх хэ-

рэг. Өчүүхэн миний бие анх түрүүнд Хүрээнээ ирж Монгол тусгаар улс болох их хэргийг нууц гаргаж, Богд эзэнд үүсгэн эхлэх тухай мэдүүлж байхад Эрдэнэ жүн ван үхширтэл унтаж, зүүдлээ ч үгүй байсныг хэн ч цөм мэднэ»¹⁰ гэж үндэсний эрх чөлөөний хувьсгалд гүйцэтгэсэн үргээ нотолсон байдаг. Хайсан цагаадаж ажилдаа эргэн орсон боловч үзэл санаа нийлдэггүй, заргалдаж гүтгэсэн хүмүүс нь эрхэлсэн ажилдаа хэвээр байсан, гурван улсын хэлэлцээрээр Монголын тусгаар тогнолыг эвдэж, өөртөө засах эрхтэй болгосон зэрэг явдал нь түүний урмыг хугалжээ.

«

Энэ цагаас Хайсан Монголын тусгаар тогтнолыг бэхжүүлэх тэмцэлд чин сэтгэлээр зүтгэж эхэлсэн байна. Түүнд үзүүлсэн хүндэтгэлийг Монголын зарим сайд ноёд эхнээсээ таагүй хүлээн авсан байдаг. Үүнийг ч тэрээр мэдэрч байсан баримт бий

»

Хайсанг 1915 оны сүүлчээр Бээжинд буцаж очиход Монголын тусгаар тогтнолын төлөө тэмцэлд оролцсон Дундад улсын иргэдийн хэргийг хөөн хэлэлцэхгүй гэсэн Гурван улсын хэлэлцээрийн ёсоор Ерөнхийлөгч Юань Ши кай хүлээн авч “гүнгийн зэрэг шагнаан, замын сүйтгэл таван мянган төгрөг олгосон” тухай «Монголын сонин бичиг» сонинд мэдээлсэн бол, “Чин зүтгэлт Хайсан 1917 онд өвчнөөр нас барсан” тухай «Нийслэл Хүрээний сонин бичиг»-т бичсэн билээ. Энэ бүхнээс үзэхэд сэтгүүлч Баянтөмөрийн Хайсан бол ХХ зууны эхэн үед монгол үндэстний дотроос төрөн гарсан үндэсний эрх чөлөөний төлөө тууштай тэмцэгч, улс төрийн томоохон зүтгэлтэн, нэр нөлөө бүхий хүн байжээ гэсэн дүгнэлт хийж болох юм.

Ишлэл

- ¹ Ширэндэв Б. 1963. XIX-XX зууны зааг дахь Монгол орон. (Орос хэлээр). М., 73 дахь тал.
- ² Ширэндэв Б. 1969. Монгол ардын хувьсгалын түүх. УБ., 30 дахь тал.
- ³ Дэлэг Г. 2014. Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл. УБ., 62 дахь тал.
- ⁴ 1984. Өвөр Монголын түүхийн материал. Эмхтгэл-14. (Хятад хэлээр). Хөххот., 157-163 дахь тал.
- ⁵ Жамсран Л. 1992. Монголчуудын сэргэн мандалтын эхэн. (1911-1913). УБ., 146 дахь тал.
- ⁶ 1977. “Гакухо” сэтгүүл. №57. Токио., 120 дахь тал.
- ⁷ Густав Жон Рамстедт. 2015. Зүүн тийш зорчсон долоон аян. УБ., 244 дахь тал

⁸ Густав Жон Рамстедт. 2015. Зүүн тийш зорчсон долоон аян. УБ., 245 дахь тал

⁹ Густав Жон Рамстедт. 2015. Зүүн тийш зорчсон долоон аян. УБ., 253 дахь тал

¹⁰ Норовсүрэн Л. 2013. Сэтгүүл зүйн онол, түүхийн асуудлууд. УБ., 204 дэх тал.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Ширэндэв Б. 1963. XIX-XX зууны зааг дахь Монгол орон.(Орос хэлээр). М.,
2. Ширэндэв Б. 1969. Монгол ардын хувьсгалын түүх. УБ.,
3. Дэлэг Г. 2014. Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл. УБ.,
4. Норовсүрэн Л. 2000. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. (Тэргүүн боть). УБ.,
5. Норовсүрэн Л. 2012. Монгол хуучин сонин, сэтгүүлийн товч лавлах. УБ.,
6. Норовсүрэн Л. 2012. ХХ зууны эхэн үеийн монгол сэтгүүлчид. УБ.,
7. 1984. Өвөр Монголын түүхийн материал. Эмхтгэл-14. (Хятад хэлээр). Хөххот.,
8. Жамсран Л. 1992. Монголчуудын сэргэн мандалтын эхэн. (1911-1913). УБ.,
9. 1977. “Гакухо” сэтгүүл. №57. Токио.,
10. Густав Жон Рамстедт. 2015. Зүүн тийш зорчсон долоон аян. УБ.,
11. Норовсүрэн Л. 2013. Сэтгүүл зүйн онол, түүхийн асуудлууд. УБ.,

Summary

In this article, some political acts of journalist B.Khaisan, who was editor of “Mongolian Newspaper” published in Kharbin and born in Kharchinkhoshuu, Inner Mongolia, were discussed. Evidences were given on that he was one of the main leaders of national revolution of Mongolia in 1911.